

Golomt Capital®


# Дотоодын зах зээлийн

ДОЛОО  
ХОНОГИЙН  
ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.04.18

Анхаарлын төвд

Индексийн өдрийн  
өөрчлөлт

МХБ ИНДЕКС	7 хоног	1 сар	1 жил
ТОП 20	-1.85%	2.86%	9.47%
MSE A	-5.92%	-6.44%	26.63%
MSE B	-0.31%	2.66%	5.99%

	Дүн (сая.төг)	Өөрчлөлт %
Зах зээлийн үнэлгээ	5,128,731.3	-4.3%
Арилжигдсан дүн	2,367.7	9.1%

ИХ АРИЛЖААЛ АГДСАН	Хаалтын ханш	Үнийн дүн
АПУ	1,389	347,724,260
Бодь Даатгал	130.00	311,136,164
Ард Санхүүгийн Нэгдэл	4,899	308,285,299
Инвектор ББСБ	4,400	249,175,627
Эрдэнэ Ресурс Девелопмент	900.00	170,930,014

ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ	Хаалтын ханш	Өөрчлөлт %
Монгол Нэхмэл	4,725	23.91%
Олоо	22.00	15.79%
Дархан Хөвөн	9,750	14.71%
Хишиг Уул	718	12.19%
Ремикон	22.00	10.00%

## АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ | 2022/04/11-04/15

- Тайлант долоо хоногт МХБ-ийн арилжаагаар нийт 62 төрлийн 2.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5,094,164 үнэт цаасны арилжаа хийгдлээ.
- Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5,129 тэрбум төгрөг болсон бол ТОП-20 индекс 37,496 нэгж болж өнгөрсөн долоо хоногоос 1.85%-иар буурсан байна. Түүнчлэн MSE A индекс 13,002 нэгжид хүрч 5.92%-иар буурсан бол MSE B индекс 12,219 нэгжид хүрч 0.31%-иар буурсан үзүүлэлттэй байна.
- Хамгийн өндөр өсөлтийг Монгол Нэхмэл (MNH) 23.91%, Оллоо (OLL) 15.79%, Дархан Хөвөн (DAH) 14.71%-иар тус тус үзүүллээ.
- Хамгийн их уналтыг Авто Импекс (AOI) -14.45%, Мик Холдинг (MIK) -13.01%, Дархан Гурил Тэжээл (DAR) -12.01%-иар тус тус үзүүллээ.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Бодь Даатгал ХК ХонгКонгийн бирж дээр  
давхар бүртгүүлнэ

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ийн 1 дүгээр ангилалд бүртгэлтэй Бодь Даатгал ХК нь 2030 он гэхэд ХонгКонг улсын бирж дээр давхар бүртгэлтэй болсон байхаар зорьж ажиллаж буйгаа 4 сарын 12-нд болсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлынхаа үеэр мэдэгдлээ.

- 2021 онд Бодь Даатгал ХК нь 54 тэрбумын нийт хураамжийн орлоготой ажилласан нь салбартаа хамгийн өндөр үзүүлэлт байсан ба нийт салбарийн хураамжийн орлогын 22 хувийг бүрдүүлсэн байна.
- Харин цэвэр ашгийн хэмжээ өмнөх оныхоос 55 хувиар буурч, 855 сая төгрөгт хүрсэн байна.
- 2022 онд тус компани нь нийт хураамжийн орлогоо 27 хувиар нэмэгдүүлж, хохирлын харьцаагаа 45 хувьд барих зорилт таван ажиллаж байна. Мөн даатгалын үйл ажиллагааны зардлыг автоматжуулалснаар үйл ажиллагааны зардлаа бууруулж, 2022 онд цэвэр ашгаа 6 тэрбум төгрөгт хүргэх төлөвлөгөөтэй байна.

Бөөний Худалдаа ХК компанийн хэлбэрээ  
өөрчилж ХХК болно

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ийн 3 дугаар ангилалд багтдаг Бөөний худалдаа (BHL) компани хэлбэрээ өөрчлөн "ХХК" болохоор төлөвлөж байгаа ба ирэх сард хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцэхээр болсон байна. Тус компани нь өмч хувьчлалын үеийн компани бөгөөд өнгөрөгч онд түрээсийн үйл ажиллагаанаас 6.0 сая төгрөгийн орлого олж, 500 мянган төгрөгийн цэвэр алдагдалтай ажилласан байна. Бөөний худалдаа компанийн хувьцааны 78.45%-ийг хамаарал бүхий 2 хувьцаа эзэмшигч эзэмшдэг бол үлдсэн хувийг 1,500 гаруй жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Их уналттай	Хаалтын ханш	Өөрчлөлт %
Авто Импекс	3,250	-14.15%
Мик Холдинг	12,700	-13.01%
Дархан Гурил Тэжээл	4,250	-12.01%
АПУ	1,389	-10.44%
Булган Ундрага	103,100	-10.27%

ӨНДӨР ҮНЭЛГЭЭТЭЙ ТОП-5	Хаалтын ханш	Үнэлгээ, тэрбум. Төг
АПУ	1,389	1,476.5
Тавантолгой	6,920	364.4
Инвескор ББСБ	4,400	315.6
МИК	12,700	263.0
Эрдэнэ Ресурс Девелопмент	900	262.7

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Инфляцын түвшин	14.4%
Бодлогын хүү	9.0%
Хадгаламжийн дундаж хүү (төгрөг)	6.5%
Хадгаламжийн дундаж хүү (ам.доллар)	2.44%
Зээлийн дундаж хүү (төгрөг)	13.8%
Зээлийн дундаж хүү (ам.доллар)	11.3%

### ХАРИЛЦАГЧИЙН БОЛОВСРОЛД: МӨНГӨНИЙ БОЛОН ТӨСВИЙН БОДЛОГО ВАЛЮТЫН ХАНШИНД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Мөнгөний болон төсвийн бодлогууд нэгдсэн байдлаар валютын ханшинд ямар нөлөө үзүүлэх нь капиталын шилжилт хөдөлгөөн (capital mobility) буюу нэг улсаас нөгөө улс руу хөрөнгийг шилжүүлэхэд амар хялбар байгаа эсэхээс хамаардаг. Тухайлбал, мөнгөний болон төсвийн бодлого хоёулаа тэлэх чиглэлд байх үед капиталын шилжилт хөдөлгөөн бага байвал дотоодын валютын ханш сулардаг бол хоёулаа хумих чиглэлд байх үед чангардаг. Харин мөнгөний тэлэх, төсвийн хумих бодлого баримталж байх үед капиталын хөдөлгөөн өндөр байх нь дотоодын валют сулрах нөлөөтэй байдаг бол мөнгөний хумих, төсвийн тэлэх бодлого нь дотоодын валют чангарах нөхцөлийг бий болгодог байна.

### ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

**Монгол улсын хэмжээнд 2022 оны 3 дугаар сарын байдлаар инфляц 14.4 хувьд хүрлээ.**

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк

2022 оны 3 дугаар сарын байдлаар Монгол улсын хэмжээнд инфляцийн түвшин **14.4** хувьд хүрсэн бол Улаанбаатар хотын хэмжээнд **15.8** хувьд хүрчээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад **5.8** дахин, сүүлийн гурван жилийн дундажтай харьцуулахад **2.8** дахин өндөр үзүүлэлт болж байна.

Инфляцийн түвшинг бараа бүтээгдэхүүний бүлгийн задаргаагаар харвал бензин **55** хувь, хүнсний зүйлс 18.1 хувь, орон сууц 14.7 хувь, эм тариа 14.2 хувь, гар ахуйн бараа 12.4 хувь, хувцас 11.5 хувь, согтууруулах ундаа болон тамхи 7.5 хувь, боловсролын бүтээгдэхүүн үйлчилгээ 3.4 хувиар тус тус үнэ нь нэмэгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүнүүдээс хүнсний ногоо болон төрөл бүрийн өөх тосны үнэ өмнөх оны мөн үеэс 44 болон 41.3 хувиар тус тус өссөнөөр хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн байна.

**Монгол Улсын төсвийн тэнцэл 3 дугаар сарын байдлаар 51.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа**

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Үндэсний Статистикийн Хорооны мэдээлснээр Монгол улсын нэгдсэн төсвийн орлого 2022 оны 3 дугаар сард 1.3 их наяд төгрөг байсан ба он гарснаас хойш өссөн дүнгээр 3.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 36 хувиар өссөн үзүүлэлт болж байгаа юм. Харин нэгдсэн төсвийн зарлага 3 дугаар сард 1.4 их наяд төгрөг гарснаар тухайн сард 51.5 тэрбум төгрөгийн төсвийн алдагдалтай гарсан байна.

**Дэлхийн банкны төсөөллөөр Монгол Улсын эдийн засаг дунджаар 2.5 хувиар өсөх ба хамгийн муу төсөөллөөр 0.7 хувиар өсөхөөр хүлээгдэж байна**

Эх сурвалж: Дэлхийн банк

Улс орнуудын эдийн засгийн өсөлт буурахад дараах 3 хүчин зүйл нөлөөлөхийг Дэлхийн банкнаас дурдлаа. Эдгээрт:

1. АНУ-ын өндөр инфляц, чангарч буй мөнгөний бодлого;
2. БНХАУ-ын "О-ковид" бодлого, үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал;
3. ОХУ-Украины хурцадмал нөхцөл байдал, түүнээс улбаатай тодорхой бус байдал тус тус багтаж байна.

Дээрх 3 гадаад хүчин зүйлийн улмаас гадаад шокоос хүчтэй хамааралтай Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2.7 нэгж хувиар бууруулж 2.5 нэгж хувьд хүргэлээ.


## АРИЛЖААНЫ БАНКУУДЫН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Балансын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр	Хаан	ХХБ	Голомт	Төрийн	Хас	Капитрон	Транс	Чингис Хаан	Богд	Үндэсний хөрөнгө оруулалт	Ариг
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,549.1	2,252.6	2,378.4	817.6	462.7	382.8	131.4	0.5	123.2	1.7	1.1
Зээл (цэвэр дүнгээр)	6,708.3	4,531.3	3,261.5	2,250.5	1,787.5	626.4	423.6	192.7	146.6	7.0	16.7
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>13,572.3</b>	<b>9,575.6</b>	<b>7,900.5</b>	<b>3,799.3</b>	<b>3,475</b>	<b>1284.1</b>	<b>713.2</b>	<b>301.4</b>	<b>327.1</b>	<b>102.3</b>	<b>102.3</b>
Харилцах	2,930.0	1,765.2	1,764.3	658.3	461.4	189.8	58.2	167.9	26.9	63.8	3.3
Хадгаламж	7,038.1	3,868.5	3,570.8	2,187.6	1,790.7	554.9	259	57.6	95.7	69.5	31.1
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>12,168.9</b>	<b>8,506.4</b>	<b>7,304.5</b>	<b>3,405.8</b>	<b>3,106.7</b>	<b>1150.1</b>	<b>540.4</b>	<b>293.5</b>	<b>225.5</b>	<b>169.6</b>	<b>66.5</b>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	172.1	323.8	194.7	178.0	100.0	100.0	146.5	42.7	81.8	35.1	50.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,018.1	612.4	191.5	172.6	202.3	24.6	26.2	-35.6	20.5	(106.7)	(14.5)
<b>Өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>1,403.5</b>	<b>1,069.2</b>	<b>596.0</b>	<b>393.5</b>	<b>368.0</b>	<b>133.9</b>	<b>172.8</b>	<b>5.7</b>	<b>101.6</b>	<b>(67.4)</b>	<b>37.7</b>
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>13,572.3</b>	<b>9,575.6</b>	<b>7,900.5</b>	<b>3,799.3</b>	<b>3,475</b>	<b>1284.1</b>	<b>713.2</b>	<b>301.4</b>	<b>327.1</b>	<b>102.3</b>	<b>102.3</b>
Чанаргүй зээлийн хувь	5.1%	13.8%	7.6%	9.5%	4.4%	9.2%	2.8%	24.2%	3.6%	-	-
<b>Орлогын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр</b>											
Хүүгийн орлого	1,182.3	576.0	576.1	372.6	327.5	100.4	50.7	22.7	25.9	9.7	6.4
Хүүгийн зардал	569.5	403.0	330.5	190.1	177.2	61.6	24.9	5.2	10.7	2.9	2.6
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>612.8</b>	<b>173.0</b>	<b>245.6</b>	<b>182.5</b>	<b>150.3</b>	<b>38.7</b>	<b>25.8</b>	<b>17.5</b>	<b>15.2</b>	<b>6.8</b>	<b>3.8</b>
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	541.7	157.2	208.8	151.1	149.9	14.0	25.2	9.1	14.3	(-32.6)	(5.1)
Бусад орлого	290.6	213.9	98.3	38.0	43.8	21.8	4.3	0.8	9.4	90.4	2.8
Бусад зардал	445.8	281.3	273.9	123.5	103.2	27.4	16.2	9.7	12.2	51.1	0.1
<b>Татварын дараах ашиг, алдагдал</b>	<b>291.5</b>	<b>89.7</b>	<b>22.1</b>	<b>51.5</b>	<b>62.2</b>	<b>7.2</b>	<b>10.6</b>	<b>0.08</b>	<b>10.2</b>	<b>6.7</b>	<b>(-3.6)</b>
<b>Шалгуур харьцаа үзүүлэлтүүд</b>											
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >9%	15.60%	15.10%	12.98%	15.68%	17.40%	14.69%	32.0%	2.6%	49.58%	-42.50%	39.51%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа >12%	15.60%	15.10%	13.28%	15.68%	17.40%	14.69%	32.0%	2.6%	49.58%	-42.50%	39.51%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >20%	46.87%	40.57%	41.30%	31.72%	44.30%	37.70%	32.9%	-7.6%	45.19%	1.00%	64.49%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) <+-15%	-1.87%	-10.47%	11.98%	9.32%	-1.10%	-8.48%	-2.4%	-211.4%	5.65%	72.00%	11.51%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа <+- 30%	-2.16%	-15.34%	15.11%	10.66%	-2.20%	-18.13%	-4.8%	-310.5%	6.13%	80.30%	11.83%

Эх сурвалж: Арилжааны банкуудын албан ёсны вебсайт

## МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, тэрбум төгрөгөөр



Бодит сектор (их наяд төгрөг)	2020Q4	2021Q4	Өөрчлөлт, дүнгээр	Өөрчлөлт, хувиар
Нэрлэсэн ДНБ	37.5	43.0	5.5	14.9%
Бодит ДНБ, 2015 зэрэгцүүлэх үнээр	26.7	27.0	0.3	1.4%
Бодит ДНБ өсөлт	-4.6%	1.4%	6.0%	-
Ажилгүйдлийн түвшин	6.6%	8.8%	2.2%	-
инфляцын түвшин	2.3%	13.4%	11.1%	-
Гадаад сектор (сая ам.доллар)				
Гадаад худалдааны эргэлт	12,875.2	16,095.8	3,224	25.0%
Экспортын хэмжээ	7,576.3	9,247.1	1,670.8	24.9%
Импортын хэмжээ	5,298.9	6,848.6	1,549.5	30.5%
Гадаад худалдааны тэнцэл	2,277.4	2,398.5	121.10	5.3%
Төсвийн сектор (их наяд төгрөг)				
Тэнцвэржүүлсэн орлого	10.4	14.3	3.9	37.0%
Тэнцвэржүүлсэн зарлага	14.0	15.6	1.6	11.7%
Тэнцвэржүүлсэн тэнцэл	(3.6)	(1.3)	2.2	62.3%
Мөнгөний сектор (их наяд төгрөг)				
Мөнгөний нийлүүлэлт	24.2	27.9	3.7	15.0%
Нийт хадгаламж	18.0	19.0	1.0	5.4%
Нийт харилцах	5.4	8.0	2.6	47.5%
Нийт зээлийн үлдэгдэл	17.0	20.7	3.7	21.3%
Хугацаа хэтэрсэн зээл	1.3	0.9	-0.4	-26.3%
Чанаргүй зээл	2.0	2.1	0.1	3.5%
Чанаргүй зээлийн хувь	11.8%	10.0%	-1.8%	-
Бодлогын хүү	8%	6%	-2.0%	-

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк, Сангийн Яам

Бүх секторүүдийн үзүүлэлтүүдийг 2020 болон 2021 оны 4 дүгээр улирлын байдлаарх тоон үзүүлэлтүүдэд тулгуурлан гаргалаа.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Симбол	APU	AIC	AARD	NEH	BODI	GOV	LEND	MMX	MFC	SUU	TTL	TUM
Компанийн нэр	АПУ	Ард Даатгал	Ард Санхүүгийн Нэгдэл	Дархан Нэхий	Бодь Даатгал	Говь	ЛендМН ББСБ	Мах импекс	Монос Хүнс	Сүү	Таван Толгой	Түмэн Шувуут
Салбар	Хүнсний үйлдвэрлэл	Санхүү	Санхүү	Хөнгөн үйлдвэрлэл	Санхүү	Хүнсний үйлдвэрлэл	Санхүү	Хүнсний үйлдвэрлэл	Хүнсний үйлдвэрлэл	Хүнсний үйлдвэрлэл	Уул уурхай	Хөдөө аж ахуй
Хаалтын ханш	1,389	954.71	4,899	22.9	130	279	37.8	3,610	113.45	559.5	6,920	501.9
САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тэрбум төгрөг)												
Хөрөнгө	617.3	34	332.6	77.4	46.4	299.9	39.3	29.2	23	84.5	154.7	47.5
Өр төлбөр	112.5	15.7	22.7	21.5	31.7	270.7	19.5	24.2	5.9	51.5	94.4	17.4
Эздийн өмч	504.7	18.3	263.3	55.9	14.8	29.1	19.8	5.01	14.9	33	60.3	30.1
Борлуулалтын орлого	669.7	15.8	22.2	23.4	17.1	144.3	12.5	49.2	18.8	100.4	179.3	35.9
Цэвэр ашиг	153.5	7.1	1.3	3.6	2.3	-38	4	1.4	2	9.4	15.1	6.9
ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД												
Эргэлтийн харьцаа	4.1	2	1.2	1.7	1.4	0.5	1.9	1.1	1.7	0.8	1.5	1.2
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	2.6	2	1.2	1	1.4	0.5	1.9	0.6	0.7	0.5	1.1	0.8
Өр ба хөрөнгийн харьцаа	18%	46%	7%	28%	68%	90%	50%	83%	26%	61%	61%	37%
Өр ба өмчийн харьцаа	82%	86%	9%	38%	214%	930%	98%	483%	40%	156%	157%	58%
Хөрөнгийн өгөөж	22%	21%	0%	5%	5%	-13%	10%	5%	9%	11%	10%	15%
Эздийн өмчийн өгөөж	30%	39%	0%	6%	16%	-130%	20%	28%	14%	29%	25%	23%
Нийт ахиуц ашиг	50%	83%	100%	32%	112%	41%	78%	3%	45%	27%	13%	31%
Цэвэр ахиуц ашиг	23%	45%	6%	15%	13%	-26%	32%	3%	11%	9%	8%	19%
P/E*	9.6	3.4	105.0	6.9	13.1	-5.7	7.6	10.0	22.9	20.5	26.4	14.5
P/B*	2.9	1.3	0.5	0.5	2.1	7.5	1.5	2.7	3.1	5.8	6.0	3.1
P/S*	2.2	1.8	6.3	1.1	1.6	1.5	2.9	0.3	2.5	1.9	2.0	2.8

\*P/E, P/B, P/S харьцаа үзүүлэлтийг тооцоход:

• Нийт компаниудын санхүүгийн үзүүлэлтийг 2021 оны тайланд үндэслэж тооцсон болно.



## ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Цэвэр ашиг, сая төг.	Нийт ногдол ашиг, сая төг.	Ногдол ашиг тараалтын хувь	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг, төг.	Ногдол ашиг тараах өдөр
1	Түмэн шувуут	6,940	<b>2,082</b>	30%	<b>10.41</b>	07/01/2022
2	ЛэндМН ББСБ	3,891	<b>1109</b>	28%	<b>1.50</b>	04/30/2022
3	Улаанбаатар БҮК	3,014	<b>1,315</b>	44%	<b>10.00</b>	06/01/2022
4	Тахько	565	<b>129</b>	29%	<b>108.00</b>	05/01/2022
5	Тандэм Инвест ББСБ	972	<b>961</b>	99%	<b>0.85</b>	12/31/2022
6	Бодь Даатгал	2,340	<b>1,177</b>	50%	<b>5.00</b>	06/30/2022
7	Дархан Нэхий	3,641	<b>300</b>	8%	<b>0.27</b>	12/31/2022
8	Материал Импекс	5,153	<b>315</b>	6%	<b>230</b>	04/30/2022
9	Гутал	2,248	<b>2,248</b>	100%	<b>1,427</b>	05/04/2022
10	Талх Чихэр	5,140	<b>256</b>	5%	<b>250</b>	10/01/2022
11	АПУ				<b>60</b>	12/31/2022
12	Би Ди Сек	1635	<b>685</b>	42%	<b>50</b>	06/30/2022
13	Улаанбаатар Хивс	733	<b>486</b>	66%	<b>1,200</b>	03/10/2022
14	Монос Хүнс	2030	<b>818</b>	40%	<b>2</b>	09/01/2022
15	Мах Импекс	1,369	<b>380</b>	28%	<b>100</b>	10/01/2022
16	Ард Даатгал	7,124	<b>1,000</b>	15%	<b>40</b>	07/30/2022
17	Ард Кредит	4,193	<b>1,260</b>	30%	<b>4,5</b>	07/01/2022
18	Сүү	9,401	<b>1,589</b>	17%	<b>4.62</b>	05/01/2022
19	Барилга Корпораци				<b>500</b>	04/14/2022
20	Гермес Центр	938	<b>499</b>	53%	<b>6,36</b>	03/15/2022
21	Мандал Даатгал	5607	<b>1,873</b>	33%	<b>3</b>	12/31/2022
22	Ард Санхүүгийн Нэгдэл	1,334	<b>1,333</b>	99%	<b>46.58</b>	06/22/2022
23	Монгол Базальт	1,929	<b>964</b>	50%	<b>17.09</b>	12/30/2022
24	Таван Толгой	15,065	<b>13,535</b>	89.8%	<b>257</b>	10/01/2022
25	Инвескор ББСБ		<b>1,793</b>		<b>25</b>	06/30/2022
26	Монгол Шуудан	400	<b>200</b>	50%	<b>2</b>	05/01/2022
27	Мон-Ит Булигаар				<b>600</b>	07/01/2022
28	Ариг Гал	554	<b>135</b>	24%	<b>39.9</b>	06/30/2022
29	Ган Хийц	4	<b>24</b>	100%	<b>100</b>	07/01/2022
31	Техник Импорт	4,329	<b>723</b>	16.7%	<b>500</b>	03/10/2022
32	Хүрд	4,095	<b>227</b>	7%	<b>1,677</b>	03/15/2022
33	Эрдэнэт Суврага	21	<b>780</b>	100%	<b>5</b>	06/30/2022

## Бэлтгэсэн:

---



**Р.Дарханбаяр**  
Хөрөнгө оруулалтын шинжээч

[Darkhanbayar@golomtcapital.com](mailto:Darkhanbayar@golomtcapital.com)  
+976 9490 4321

---

**Golomt Capital<sup>®</sup>**

---